



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 81

Улаанбаатар хот

### Тусгаарлагдсан хувьцааг чөлөөлөх тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4.3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 70 дугаар тогтоолоор 6 сарын хугацаанд тусгаарлагдсан “Инвескор ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хувьцааны тусгаарлалтын хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан энэхүү тогтоолын хавсралтад заасан хувьцаа эзэмшигчдийн хувьцааг тусгаарлалтаас чөлөөлөхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ж.Байгалмаа/-д үүрэг болгосугай.

2. Энэхүү тогтоолын хавсралтад заасан хувьцааг тусгаарлалтаас чөлөөлөхтэй холбоотой ажиллагааг ажлын 10 хоногт багтаан гүйцэтгэж, холбогдох тайланг ирүүлэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ж.Байгалмаа/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны  
2019 оны 02-р сарын 28-ны өдрийн  
84. дугаар тогтоолын хавсралт

“Инвекор ББСБ” ХК-ийн тусгаарлагдсан хувьцаа эзэмшигчдийн  
дансны дугаар, тоо ширхэг

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Префикс дугаар	Эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг
1	Shunji Sakamoto	1739582	270,514
2	Motokatsu Tanizawa	1740628	135,257
3	Akemi Kayama	1739575	135,257
4	Hiroshi Kawamura	1739577	1,420,000
5	Kazumitsu Hamada	1739578	270,000
6	Yasuhiro Sakamoto	1739587	2,704,000
7	Tatsuya Ono	1739584	135,000
8	Toshihiko Takayama	1739586	475,000
9	Hirohito Namiki	1739576	670,000
10	Richard Walter	93850	315,000
11	Reiko Terashima	1739581	135,000
12	Yusuke Owada	1739588	70,000
13	“Текра Монгол” ХХК	1739585	1,310,282
14	Эс Ай Би Жэй Рийл Эстэйт ХХК	1739583	1,100,000
15	Эс Ай Би Жэй Капитал ХХК	1749985	53,795,939
Нийт дүн			62,941,249